



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 312

Улаанбаатар хот

“Дилерүүдийн арилжааны төв” ХХК-д
үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 63 дугаар зүйлийн 63.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дилерүүдийн арилжааны төв” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Дилерүүдийн арилжааны төв” ХХК /С.Даваасамбуу/-д үүрэг болгосугай:

1/ Үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох дүрэм, журмыг батламжлуулах, системийг суурилуулах ажлыг 2016 оны оны 01 дүгээр улиралд багтаан гүйцэтгэх, үйл ажиллагааг эхлүүлэх;

2/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээллэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000895